



БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 IV

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	3
I. ХҮН АМ	4-5
II. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	6-7
III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ	8-13
IV. ЭРҮҮЛ МЭНД	14-16
V. ГЭМТ ХЭРЭГ	17-19
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
VI. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	20-21
VII. МӨНГӨ, ЗЭЭЛ	22-23
VIII. ТӨСӨВ	24-25
IX. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ	26-27
X. МАЛ АЖ АХУЙ	28-30
XI. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ	31-32
XII. АЖ ҮЙЛДВЭР	33-35
XIII. БАЙР СУУЦААР ХАНГАХ, НИЙТИЙН ХООЛ	36-37
XIV. ГАМШИГ ОСЛЫН МЭДЭЭ	38
ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД	39-49

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-VI, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулна).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- дахин их
- 1/X дахин бага
- # тухайн сар
- 1 оны эцэст
- | харьцуулагдахгүй

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга = \$1000\$
- сая = \$10^6\$
- тэрбум = \$10^9\$
- их наяд = \$10^{12}\$
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори (\$=10^9\$ калори)
- с секунд
- мин минут
- мкг/м³ микрограмм метр куб

- м/с метр секунд
- ————— Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



V. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын лого дээр дарж дэлгэрэнгүй мэдээллийг MS-Excel хүснэгтээр татан авах боломжтой.

(Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой)



VI. Та өөрийн гар утаснаас QR code уншигч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

(Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой)

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			2026 I-IV 2025 I-IV	
		2023	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	зөрүү	хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ									
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ	тэрбум. төг	59.4	64.5	68.1	21.6	23.7	25.1	1.4	5.5
Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдагч	тоо	74 543	74 971	71 932	65 650	63 738	61 270	-2468	3.9
ЭРҮҮЛ МЭНД									
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 616	1 418	1 268	481	441	397	-44	-10.0
Амаржсан эх	хүн	1 603	1 410	1 262	478	439	390	-49	-11.2
Нас баралт	хүн	476	458	437	130	132	120	-12	-9.1
0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	17	21	14	3	8	9	1	12.5
Нялхсын эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд ногдох	8.0	12	6.3	6.2	4.5	17.6	13.1	0.0
Эхийн эндэгдэл	хүн	0	1	1	0	0	0	0	0.0
Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	хүн	969	1 258	790	490	361	203	-158	-43.8
ГЭМТ ХЭРЭГ									
Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	тоо	395	577	706	279	361	265	-96	-26.6
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ	сая төгрөг	3 092.4	2 393.2	1 944.7	1135.9	635.2	1151.9	516.7	81.3
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт хэмжээ	сая төгрөг	876.3	625.6	574.0	259.7	135.2	168.9	33.7	24.9
Хэрэгт холбогдогсдын тоо	хүн	300.0	370.0	475.0	111	111	114	3	2.7
МӨНГӨ, БАНК									
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум .төг	321.4	497.0	615.2	379.4	543.7	638.9	95.1	17.5
Иргэдийн хадгаламж	тэрбум .төг	155.0	205.4	218.8	161.5	194.5	219.1	24.5	12.6
ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА									
Нийт тэнцвэржүүлсэн орлого	тэрбум. төг	148.2	207.7	221.7	71.9	78.1	76.9	-1.2	-1.5
Нийт зарлага	тэрбум. төг	147.9	199.1	231.7	66.2	80.5	77.1	-3.4	-4.2
Тэнцэл	тэрбум. төг	0.3	8.6	-10.0	5.8	-2.3	-0.1	2.2	-95.7
ҮНЭ									
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, өмнөх оны эцэстэй харьцуулсан	хувь	6.5	10.4	6.6	7.9	6.1	8.7	2.6	42.6
АЖ ҮЙЛДВЭР									
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	тэрбум .төг	66.9	73.2	123.1	23.5	36.4	91.4	55.0	150.7
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн борлуулалт	тэрбум. төг	66.6	73.2	122.1	23.5	36.3	91.1	54.8	150.6



ХҮН АМ


Тайлант сард 94 эх амаржиж, 95 хүүхэд төрүүлжээ.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр 2026 оны эхний 4 сард 397 хүүхэд мэндэлж, өмнөх оны мөн үеэс 44 (9.9%) буурч хүн амын цэвэр өсөлт 277 болж, өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар буурчээ

ХҮСНЭГТ 1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар


Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
	Тоо			Зөрүү	Хувь
Төрөлт	481	441	397	-44	-10.0
Нас баралт	130	132	120	-12	-9.1
Ердийн цэвэр өсөлт	351	309	277	-32	-10.4
1 000 хүнд ногдох					
Төрөлт	5.4	5.0	4.4	-0.6	-11.2
Нас баралт	1.5	1.5	1.3	-0.2	-10.3
Ердийн цэвэр өсөлт	3.9	3.5	3.1	-0.4	-11.6

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил, сараар



Тайлант хугацаанд нийт 120 хүн нас барж өмнөх оны мөн үеэс 32 (9.1%) ээр буурсан, нялхсын эндэгдэл 7 бол өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өссөн байна.

ЗУРАГ 2. НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ, жил, сараар



Ойлголт, тодорхойлолт:

Төрөлт:

Хүн төрөлхтний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент:

Тухайн жилийн 1 000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Нас баралт:

Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент:

Тухайн жилийн 1 000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт:

Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Эх үүсвэр:

Аймгийн Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<http://bayankhongor@nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 6 дугаар сарын 15

Бэлтгэсэн:

Хэлтсийн дарга Г.Ганчимэг Утас: 70442081




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Эхний 4 сарын байдлаар 70 иргэнийг ажилд зуучилсан байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээгээр 2026 оны 4 дүгээр сард бүртгэлтэй ажил хайгч иргэн 105 нэмэгдэж, 28 иргэн хасагдаж сарын эцэст 209 иргэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 95 (83.3%) өссөн. Бүртгүүлсэн ажилгүй иргэдийн 88 (42.1%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Байнгын шинэ ажлын байранд ажилд орсон 31 иргэний төрийн байгууллагад 17, хувийн хэвшилд 11, гадаадын иргэний хөрөнгө оруулалтай байгууллагад 3 иргэн ажилд оржээ.

ХҮСНЭГТ 2.

БАЙНГЫН ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 4 сард

Ажил мэргэжлийн ангилал	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
	Тоо			Зөрүү	Хувь
Бүгд	117	331	174	-157	-47.4
Менежер	3	15	12	-3	-20.0
Мэргэжилтэн	26	23	36	13	56.5
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	5	8	2	-6	-75.0
Контор, үйлчилгээний ажилтан	12	6	14	8	2.3**
Худалдаа, үйлчилгээний ажилтан	28	13	13	-	-
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	0	20	1	-19	-95.0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	2	109	4	-105	-96.3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	0	0	22	22	-
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	0	2	4	2	2.0**
Энгийн ажил, мэргэжил	41	135	66	-69	-51.1

** дахин их

Тайлант хугацаанд ажлын байрны захиалга 174 ирсэн нь өмнөх оны мөн үеэс 157(47.4%) буурсан байна.

Ойлголт тодорхойлолт:

Бүртгэлтэй ажилгүй иргэд:

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Ажил хайгч иргэд:

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхөцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Ажиллагчид:

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ.

Эх үүсвэр:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос: <http://bayankhongor@nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2026 оны 6 дугаар сарын 15

Бэлтгэсэн: Хэлтсийн дарга Г.Ганчимэг Утас: 70442081



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн үйлчилгээнд 61270 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар буурчээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр эхний 4 сарын байдлаар 61.2 мянган иргэнд 25049.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгожээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан иргэдийн тоо 2.4 (3.9%) мянган хүнээр буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 1274 (5.4%) сая төгрөгөөр өссөн.


ХҮСНЭГТ 3.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
	Тоо			Зөрүү	Хувь
Бүгд	65 662	63 750	61 270	-2 480	-3.9
Улсын төсвийн дүн	65 650	63 738	61 262	-2 476	-3.9
Халамжийн тэтгэвэр	1 856	1 957	2 052	95	4.9
Халамжийн тэтгэмж	1 933	2 160	2 374	214	9.9
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	2 062	2 113	2 323	210	9.9
Жирэмсэн эхийн тэтгэмж	959	890	762	- 128	-14.4
Алдарт эхийн одонгийн тусламж	8 130	8 282	8 549	267	3.2
Насны хишиг	4 157	4 473	4 776	303	6.8
Цалинтай ээж хөтөлбөр	4 092	3 720	3 384	- 336	-9.0
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	272	286	302	16	5.6
Ихэр хүүхдийн тэтгэмж	5	5	7	2	40.0
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	34 505	34 706	34 528	- 178	-0.5
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 151	4 596	1 643	-2 953	-64.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	114	107	149	42	39.3
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	2 412	441	411	- 30	-6.8
Алдар цолтой ахмадууд	2	2	2	0	0.0
Орон нутгийн төсвийн дүн	12	12	8	- 4	-33.3
Онцгой тохиолдлын тэтгэмж	12	12	8	- 4	-33.3

ЗУРАГ 4.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрөлд эзлэх хувь, жил бүрийн эхний 4 сарын байдлаар




Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулсан зардлын 21118.6 (84.3%) сая төгрөгийн халамжийн тэтгэмж, 3773.1 (15.1%) сая төгрөгийн халамжийн тэтгэвэрт зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
	сая.төг			Зөрүү	Хувь
Нийт	21 669.0	23 775.4	25 049.2	1 274	5.4
Улсын төсвийн дүн	21 654.6	23 761.0	25 039.6	1 279	5.4
Халамжийн тэтгэвэр	2 526.9	3 113.5	3 773.1	660	21.2
Халамжийн тэтгэмж	2 128.6	2 500.6	3 118.3	618	24.7
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	534.4	654.8	818.0	163	24.9
Жирэмсэн эхийн тэтгэмж	96.5	87.6	73.5	- 14	-16.1
Алдарт эхийн одонгийн тусламж	1 027.0	2 072.3	2 126.8	55	2.6
Насны хишиг	343.6	364.3	384.8	21	5.6
Цалинтай ээж хөтөлбөр	743.2	670.5	604.3	- 66	-9.9
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	177.1	186.6	237.6	51	27.3
Ихэр хүүхдийн тэтгэмж	10.0	10.0	14.0	4	40.0
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	13 684.6	13 727.0	13 654.7	- 72	-0.5
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	258.1	236.2	77.8	- 158	-67.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	35.2	46.6	66.5	20	42.8
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	89.0	90.8	89.4	- 1	-1.5
Алдар цолтой ахмадууд	0.5	0.2	0.8	1	4.5**
Орон нутгийн төсөв дүн	14.4	14.4	9.6	-5	-33.3
Онцгой тохиолдлын тэтгэмж	14.4	14.4	9.6	- 5	-33.3

**дахин их

ЗУРАГ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ, төрөлд эзлэх хувь, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээнд 1643 иргэнд 77.8 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс 2953 (64.3%) иргэнээр, олгосон тусламж үйлчилгээний зардал 158.0 (67.1%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн:

Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;

Байнгын асаргаа шаардлагатай иргэн:

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг;

Бүтэн өнчин хүүхэд

Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;

Өрх толгойлсон эх /эцэг/:

Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг;

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ:

Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг;

Эх үүсвэр:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос: bayankhongor@nso.mn

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2026 оны 5 дугаар сарын 15

Бэлтгэсэн:

Хэлтсийн дарга Г.Ганчимэг Утас: 70442081



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 14.3 хувиар давж биелжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого эхний 4 дүгээр сарын байдлаар 29438.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5131.7 (21.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 21588.0 (73.3%) сая төгрөг нь шимтгэлийн орлого, 7850.8 (26.7%) сая төгрөг улсын төсвийн санхүүжилт байна. Нийгмийн

даатгалын сангийн шимтгэлийн орлогын 48.2 хувийг ажил олгогчоос төлөх шимтгэл, 40.8 хувийг даатгуулагчаас төлөх шимтгэл, 5.9 хувийг сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогууд дийлэнх хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	Жил			Сар			2026 I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	дүн	хувь
	сая төгрөг							
Орлогын дүн	42 098.1	63 127.4	77 121.5	16 460.5	24 307	29 438.9	5 131.7	21.1
Тэтгэврийн даатгалын сан	32 582.6	45 932.9	68 305.7	11 468.4	21 768	25 987.6	4 219.1	19.4
Тэтгэмжийн даатгалын сан	1 375.0	5 798.0	4 885.7	1 713.4	1 431	1 877.0	445.2	31.1
ҮОМШӨ-ний даатгалын сан	505.5	1 024.0	2 318.6	337.2	641	951.0	309.1	48.2
Ажилгүйдлийн даатгалын сан	432.4	1 390.7	1 611.5	439.2	465	623.3	158.3	34.0
Эрүүл мэндийн даатгалын сан	7 202.6	8 981.7	-	2 502.3	-	-	-	-
Зарлагын дүн	91 491.1	114 906.4	131 958.8	34 904.5	43 474	49 956.1	6 481.4	14.9
Тэтгэврийн даатгалын сан	86 165.8	108 093.5	122 776.3	33 103.6	40 486	46 236.4	5 750.0	14.2
Тэтгэмжийн даатгалын сан	3 999.8	5 180.6	6 199.4	1 479.9	2 069	2 038.0	- 31.6	- 1.5
ҮОМШӨ-ний даатгалын сан	455.9	270.2	391.8	55.5	110	140.1	29.9	27.1
Ажилгүйдлийн даатгалын сан	869.6	1 362.0	2 591.3	265.6	808	1 541.6	733.2	90.7

Нийгмийн даатгалын сангийн зарлага эхний 4 дүгээр сарын байдлаар 49956.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6481.4 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 5750.0 сая, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 29.9 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 733.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна. Нийгмийн даатгалын сангийн зарлагын 92.6 хувийг

тэтгэврийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Нийгмийн даатгалаас тэтгэвэр авагчдын тоо 13856 болж, өмнөх оны мөн үеэс 273 (2.0%-оор өссөн, нийт тэтгэвэр авагчдын 82.9 хувийг өндөр настны, 12.1 хувийг хөдөлмөрийн чадвараа алдсаны, 1.2 хувийг цэргийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байна.

ХҮСНЭГТ 6.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	<u>2026 I-IV</u> <u>2025 I-IV</u>	
	тоо			Зөрүү	Хувь
Бүгд	3 169	14 635	14 798	163	1.1
Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид	2 294	13 583	13 856	273	2.0
Өндөр насны тэтгэвэр	1 517	11 209	11 499	290	2.6
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	455	1 705	1 688	- 17	-1.0
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	154	502	493	- 9	-1.8
Цэргийн алба хаагчийн тэтгэвэр	168	167	176	9	5.4
Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид	676	714	616	- 98	-13.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	128	148	145	- 3	-2.0
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	426	453	365	- 88	-19.4
Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	122	113	106	- 7	-6.2
ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авагчид	25	28	30	2	7.1
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	17	18	19	1	5.6
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	8	10	11	1	10.0
Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид	174	310	296	- 14	-4.5

Нийгмийн даатгалд даатгуулагчид 76.3 хувь албан журмын даатгуулагчид, 23.6 хувь нь сайн дураар даатгуулагчид байгаа бөгөөд сайн дураар даатгуулагчдын тоо 4992 болж өмнөх оны мөн үеэс 114 (2.3%) даатгуулагчаар өссөн байна.

ЗУРАГ 6.

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрөлд эзлэх хувь жил бүрийн эхний 4 сарын байдлаар



ХҮСНЭГТ 7.

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрлөөр, жил бүрийн 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2025 I-IV	2026 I-IV	<u>2026 I-IV</u> <u>2025 I-IV</u>	
	тоо		Зөрүү	Хувь
Бүгд	21 090	21 138	48	0.2
Албан журмын даатгуулагчдын тоо	16 212	16 146	-66	-0.4
Аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагч	10 567	10 778	211	2
Төсөвт байгууллагын даатгуулагч	5 645	5 368	-277	-4.9
Сайн дураар даатгуулагчийн тоо	4 878	4 992	114	2.3
Малчин	3 522	3 794	272	7.7
Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа	357	235	-122	-34.2
Хөгжлийн бэрхшээлтэй	53	63	10	18.9
Бусад	946	900	-46	-4.9

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал:

Иргэн, төр, аж ахуй нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан:

Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч:

Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр:

Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж:

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn>

Хэлтсийн дарга Г.Ганчимэг Утас: 70442081

Бэлтгэсэн:

Мэргэжилтэн: Ш.Жавхлантөгс 70442403

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 06 дугаар сарын 15



ЭРҮҮЛ МЭНД

Осол гэмтлийн тоо өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2026 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 117.1 мянган иргэнд үзлэг хийсний 35.2 мянга буюу 30.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. Нийт 6.7 мянган үйлчлүүлэгч эмчлэгдэн 44.3 мянган ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.6 байна.

Халдварт бус өвчлөл 28.8 мянган бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1.2 (4.2%) мянгаар буурчээ. Нийт 390 эх амаржиж, өмнөх оны мөн үеэс 49 (11.2%)-өөр буурсан, амаржсан эхчүүдийн 85.1 хувь нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан байгаа нь өмнөх оноос 10.9 хувиар буурчээ, гэрийн төрөлтийн 3 тохиолдол гарчээ.

ХҮСНЭГТ 8. ТӨРӨЛТ, жилээр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Жил			Сар			2026 I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Зөрүү	Хувь
	тоо							
Амаржсан эх	1 603	1 410	1 262	478	439	390	-49	-11.2
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	1 493	1 299	1 155	433	422	332	-90	-21.3
Гэрийн төрөлт	6	3	3	1	1	3	2	3.0**
Амьд төрсөн хүүхэд	1 616	1 418	1 268	481	441	397	-44	-10.0
1 цагийн дотор хөхөөр амласан хүүхэд	1 577	1 401	1 249	479	440	391	-49	-11.1
Төрөлхийн гажигтай төрсөн	6	9	5	4	3	2	-1	-
2500 граммаас бага жинтэй төрсөн	73	57	29	21	7	20	13	-
Амьгүй төрсөн хүүхэд	39	35	39	3	1	-	-	-

** дахин их

Осол гэмтлийн 417 тохиолдол гарсан нь, өмнөх оны мөн үеэс 36 (7.9%)-аар, хорт хавдрын өвчлөл 31 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 8 (20.5%)-аар тус тус буурчээ. Нэг хүртэлх насандаа эндсэн 7 тохиолдол бүртгэгдсэн нь

өмнөх оны мөн үеэс 3,5 дахин өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1 000 амьд төрөлтөд 17.6 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13.1 промиллоор өссөн байна.

ХҮСНЭГТ 9. НАС БАРАЛТ, НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ, жилээр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

	Жил			Сар			2026 I-IV 2025 I-IV	
	2023	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	Зөрүү	Хувь
	тоо							
Нас баралт	476	458	437	130	132	120	-12	-9.1
Эмнэлэгт нас баралт	99	97	96	30	26	30	4	15.4
Гэртээ (бусад газарт)	377	361	341	100	106	90	-16	-15.1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	4	6	-	3	1	-	-
Нялхсын эндэгдэл	13	17	8	3	5	8	-	-
Нялхсын эндэгдлийн түвшин, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдохоор	8.1	12	6.3	6.2	4.5	17.6	13.1	-

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Тайлант хугацаанд 203 халдварт өвчин бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 158 (43.8%) тохиолдлоор буурахад бэлгийн замын халдварт өвчин 48.9 хувиар буурсан голлох нөлөөг үзүүлжээ.


ХҮСНЭГТ 10. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, төрлөөр жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
	тоо			Зөрүү	Хувь
Халдварт өвчнөөр өвчлөгчид	490	361	203	-158	-43.8
Ёлом	3	3	1	-2	-66.7
Суулгалт халдвар	2	1	1		
Сүрьеэ	15	9	10	1	11.1
Салхин цэцэг	266	131	64	-67	-51.1
Тэмбүү	51	72	20	-52	-72.2
Заг хүйтэн	51	45	32	-13	-28.9
Трихоминиаз	86	60	39	-21	-35.0
Улаан бурхан		19	19		
Гахайн хавдар	1	3	0	-3	
Гар, хөл, амны өвчин	9	4	4		
Арьсны мөөгөнцөр		11	5	-6	-54.5
Халдварт гепатит		2		-2	
Хачигт риккеттиоз		1		-1	
Ковид-19	3				
Халдварт эритема			3	3	
Бусад /бүслүүр үлд/	3		5	5	

Өмнөх оны мөн үетэй хариуцуулахад гахай хавдар, халдварт гепатит, хачигт риккеттиозын өвчлөл гараагүй, халдварт эритема 3, бүслүүр үлд 5 тохиолдол шинээр

бүртгэгдэж, салхин цэцэг 67 (51.1%), тэмбүү 52 (72.2%), тус тус буурч, халдварт өвчний 31.5 хувийг салхин цэцэг, бэлгийн замын халдварт өвчин 45.0 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 7. ХАЛДВАРТ ӨВЧИН, төрөлд эзлэх хувиар 4 дүгээр сард



Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт:

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Эндсэн эх:

Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Амьгүй төрөлт:

Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эх үүсвэр:

Аймгийн Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

bayankhongor@nso.mn

Хэлтсийн дарга: Г.Ганчимэг Утас: 70442081

Бэлтгэсэн:

Ахлах мэргэжилтэн Б.Саруул Утас: 70442403

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2026 оны 6 дугаар сарын 15



ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг 265 болж өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар буурсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр 2026 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 96 (26.6%)-аар буурсан, бүртгэгдсэн гэмт хэргийн

61.5 хувь нь аймгийн төвд, 35.5 хувь нь бусад сумдад үйлдэгджээ. Гэмт хэргийн илрүүлэлт хэргийн илрүүлэлт 32.7 хувьтай, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиараа өссөн байна.

ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	2026 I-IV 2025 I-IV	
					Зөрүү	Хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	279	361	265	-96	-26.6
Аймгийн төвд	тоо	195	219	163	-56	-25.6
Сумдад	тоо	84	142	102	-40	-28.2
Гэмт хэргийн хохирогч	хүн	246	334	240	-94	-28.1
Гэмтсэн	хүн	87	91	75	-16	-17.6
Нас барсан	хүн	19	17	7	-10	-58.8
Учирсан хохирол	сая. төг	1 135.9	1 135.9	1 151.9	16	1.4
Бүртгэгдсэн зөрчил	тоо	11 360	8 982	9 645	663	7.4
Хүлээн авч шалгасан гомдол мэдээлэл	тоо	1 575	1 651	1 541	-110	-6.7

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 113 болж өмнөх оны мөн үеэс 61(35.5%) хэргээр буурсан нь залилах гэмт хэрэг болж 63(58.3%) буурсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хулгайлах гэмт хэрэг 2(5%) болж өссөн байна.


Бүлэглэн үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар өссөн, цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 60.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн байдал, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Жил		Сар			2026 I-IV 2025 I-IV	
	2024	2025	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	зөрүү	хувь
Бүлэглэн	34	47	18	12	16	4	33.3
Согтуугаар үйлдсэн	117	226	50	58	59	1	1.7
Цахим орчинд	141	124	75	99	39	-60	-60.6
Эмэгтэй хүн оролцож	88	91	40	39	27	-12	-30.8
Хүүхэд оролцсон	21	16	5	3	3	0	0.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	28	63	13	28	11	-17	-60.7
Мансуурсан үедээ үйлдсэн					1	1	-


Гэмт хэргийн улмаас иргэн хуулийн этгээдэд 1151.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 516.7 сая төгрөгөөр буюу 81.3 хувиар өссөн байна. Нийт хохирлын 14.7 хувь буюу 168.9 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

ЗУРАГ 8. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, өмчийн хэлбэр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас 240 хүн хохирч үүнээс 75 хүн гэмтэж 7 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирогч 28.1 хувиар, гэмтсэн хүн 17.6 хувиар буурсан байна.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН, хохирогчид, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 114 болж, өмнөх оны мөн үеэс 3 (12.3%)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 14 (12.3%) нь эмэгтэйчүүд, 18 хүртэлх насны хүүхэд 3 бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 10. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, хүйсээр, жил бүрийн 4 дүгээр сарын



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Хохирогч:

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагавар гэмт хэргийн хохирол тооцно.

Яллагдагч:

Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:

аймгийн Цагдаагийн газар

Мэдээлэл авах холбоос:

<http://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 06 дугаар сарын 15

Нэгтгэсэн:

Хэлтсийн дарга: Г.Ганчимэг Утас: 70442081

Бэлтгэсэн

Мэргэжилтэн Ш.Жавхлантөгс Утас: 70442403

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2026 оны 6 дугаар сарын 15



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2025 онд нэг хүнд ноогдох ДНБ 20.1 хувиар өсжээ.

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр) 2025 онд 906.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 149.1 (19.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 94.4 (28.4%) тэрбум төгрөгөөр үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг 10.8 (13.7%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 43.9 (12.6%) их тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


ХҮСНЭГТ 13. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, жилээр

Эдийн засгийн салбар	2023	2024	2025*	2025* 2024	
	Сая төгрөг			Зөрүү	Хувь
ДНБ	743 803.1	757 573.7	906 694.4	149 120.7	19.7
Хөдөө аж ахуй	384 956.4	331 673.5	426 037.2	94 363.7	28.5
Уул уурхай, олборлох	3 940.6	2 961.6	5 255.5	2 293.9	77.5
Үйлдвэрлэл, Барилга	86 477.1	75 950.4	84 469.2	8 518.8	11.2
Үйлчилгээ	268 428.9	346 988.3	390 932.5	43 944.2	12.7


*Урьдчилсан гүйцэтгэл

Нэг хүнд ноогдох ДНБ-н 10.2 сая төгрөг болж өмнөх оноос 20.1 хувиар өсжээ. Улсын дунджаас 59.0 хувиар доогуур үзүүлэлтэй байна.

ЗУРАГ 11. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, жилээр



ЗУРАГ 12. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, аймаг, нийслэлээр



Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцно.

Үйлдвэрлэлийн арга:

Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг,

Эцсийн ашиглалтын арга:

Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг,

Орлогын арга:

Ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг ойлгоно.

Үндэсний нийт орлого (ҮНО):

Тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг бөгөөд ҮНО-ыг тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн анхдагч цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Анхдагч орлогод а.харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б.хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

Эх үүсвэр:

Үндэсний Статистикийн Хороо

Мэдээлэл авах холбоос:

<http://bayankhongor.nso.mn/>

Бэлтгэж нэгтгэсэн:

Хэлтсийн дарга: Г.Ганчимэг Утас: 70442081

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 6 дугаар сарын 15



МӨНГӨ, САНХҮҮ

Хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өсжээ.

Монгол банкны Баянхонгор аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2026 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар арилжааны

банкнуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл 638.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 95.1 (17.5) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.


ХҮСНЭГТ 13. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2024 I-IV	2025 I-IV	2026 I-IV	<u>2026 I-IV</u> <u>2025 I-IV</u>	
	сая төгрөг			Зөрүү	Хувь
Нийт	379 431.8	543 760.7	638 904.0	95 143.3	17.5
Хэвийн зээл	367 022.3	525 634.6	619 089.4	93 454.8	17.8
Анхаарал хандуулах зээл	5 786.9	10 181.5	8 143.5	-2,038.0	-20.0
Чанаргүй зээл	6 622.6	7 944.6	11 671.1	3 726.5	46.9


Эх үүсвэр: Аймгийн Монгол банк

Чанаргүй зээлийн ангилалд орсон 924 зээлдэгчийн 720 (77.9) нь хэрэглээний зээл авсан байна.

ЗУРАГ 13. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



ЗУРАГ 14. ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, төрлөөр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Тайлант хугацааны эцэст нийт хадгаламжийн үлдэгдэл 221.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 21.4 (10.6%) тэрбум төгрөгөөр нэмэгдэж, иргэдийн хадгаламж 98.7 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хадгаламж: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл:

Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл:

Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл:

Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр:

аймгийн Монгол банкны салбар,

Мэдээлэл авах холбоос:

bayankhongor@nso.mn

Нэгтгэсэн:

Хэлтсийн дарга: Г.Ганчимэг Утас: 70442081

Бэлтгэсэн:

Ахлах мэргэжилтэн Б.Саруул Утас: 70442403

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 06 дугаар сарын 15



ТӨСӨВ

Нийт татварын орлогын төлөвлөгөө 35.8 хувиар давж биелжээ.

Орон нутгийн төсвийн орлого 2026 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 33.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.2 (18.7%) тэрбум, төсвийн зарлага 32.8 тэрбум 2.5 (1.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

ХҮСНЭГТ 14. ОРОН НУТГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2025 I-IV	2026 I-IV*	2026 I-IV* 2025 I-IV	
	сая төгрөг		дүн	хувь
Төсвийн орлого	27 759.9	33 016.9	5 257.0	18.9
Татварын орлого	11 121.4	15 802.3	4 680.9	42.1
Татварын бус орлого	1 062.8	1 399.3	336.5	31.7
Тусламжийн орлого	15 575.7	15 815.2	239.6	1.5
Төсвийн зарлага	30 208.4	32 804.9	2 596.4	8.6
Бараа үйлчилгээний зардал	25 387.4	24 705.4	-682.0	-2.7
Урсгал шилжүүлэг	549.0	1 568.9	1 020.0	185.8
Хөрөнгийн зардал	4 272.0	6 530.5	2 258.5	52.9

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

Татварын газрын мэдээгээр 2026 оны эхний 4 сарын байдлаар 18.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж биелэлт 33.9 хувиар давж биелсэн байна. Улсын төсөвт 2.4 тэрбум, аймгийн төсөвт 2.0 тэрбум, сумдын төсөвт 13.3 тэрбум төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

ХҮСНЭГТ 15. ТАТВАРЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний 4 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	13 936.8	18 658.4	4 721.6	33.9
Нийт татварын орлого дүн	13 077.7	17 758.9	4 681.2	35.8
Улсын төсөв	2 265.4	2 432.7	167.3	7.4
Орон нутгийн төсөв	11 671.4	16 225.6	4 554.1	39.0
Аймгийн төсөв	744.0	2045.5	1 301.5	174.9
Сумын төсөв	10 068.4	13 280.7	3 212.3	31.9
Төлбөр хураамжийн дүн	762.5	852.3	89.8	11.8
Улсын тэмдэгтийн хураамж	36.4	15.1	-21.3	-58.5
Газрын төлбөр	140.9	321.2	180.3	128.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал	87.5	2.9	-84.6	-96.7
Хог хаягдлын хураамж	486.8	489.5	2.7	0.6
Ус рашаан ашигласны төлбөр	10.8	23.4	12.6	116.7
Ан агнуурын нөөц ашигласны	-	0.4	0.4	-
Татварын бус орлого дүн	859.1	899.4	40.3	4.7
Хүү торгуулийн орлого	807.2	827.2	20	2.5
Газрын дуудлага худалдаа	1.2	-	-1.2	-
Төрийн байгууллагын өөрийн орлого	50.7	72.2	21.5	42.4

Эх үүсвэр: Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

Ойлголт тодорхойлолт

Орон нутгийн төсвийн зарлага:

Урсгал зардал, хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

Татварын орлого:

Орлогын албан татвар, өмчийн албан татвар, бусад татвар, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Орлогын албан татвар, өмчийн албан татвар, бусад татвар, хураамжаас бүрдэнэ.

Хөрөнгийн орлого:

Түрээсийн орлого, хүүгийн орлого, торгуулийн орлого, нэр зааж ангилагдаагүй орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдэнэ Үндсэн хөрөнгө борлуулсны орлого, дуудлага худалдааны орлогоос бүрдэнэ.

Эх үүсвэр:

Санхүү төрийн сангийн хэлтэс Татварын газар

Мэдээлэл авах холбоос:

bayankhongor@nso.mn

Нэгтгэсэн:

Хэлтсийн дарга Г.Ганчимэг Утас 70442081

Мэргэжилтэн Ч.Эрдэнэбат Утас: 70442403

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 6 дугаар сарын 15




ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар өслөө

Аймгийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 4 дүгээр сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар, өмнөх сараас 1.7 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 15. БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар 2026 оны 4 дүгээр сард



